

БАТЛАВ

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ ОЙН ГАЗРЫН ДАРГА

Б.ОЮУНСАНАА

БАЙГАЛИЙН СЭРГЭН УРГАЛТАД ТУСЛАХ АЖЛЫН
ДААЛГАВАР /ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ/

| № | Нэр төрөл, үзүүлэлт | Шаардлага |
|----|-----------------------------|---|
| 1 | Үндэслэл | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын даргын 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн А/10 дугаар тушаалаар батлагдсан “Ойжуулалт хөтөлбөрийн 2024 онд үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх шинэчилсэн төлөвлөгөө”-д тусгагдсан байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж гүйцэтгэнэ. |
| 2 | Ажлын хамрах хүрээ | Байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж гүйцэтгэнэ. Талбайн байршлыг ажлын даалгаварт хавсаргав. |
| 3 | Гүйцэтгэх ажил | Байгалийн сэргэн ургалтад туслах |
| | Төсөвт өртөг | 592,000,000.00 /таван зуун ерэн хоёр сая/ төгрөг |
| 4 | Талбайн хэмжээ | 800 га талбай |
| 5 | Техникийн шаардлага | Байгалийн сэргэн ургалтад ажлыг гүйцэтгэх байгууллага нь ойжуулалт, тарьц суулгац, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой стандартуудыг мөрдөж ажиллана. |
| 6 | Модны төрөл | Тухайн сонгогдсон байршилд зонхилон ургаж буй төрөл |
| 7 | Хугацаа | Байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг 4-р сарын 30-аас 6-р сарын 10 хүртэл, 9-р сарын 25-аас 11-р сарын 1-ний дотор дуусталх хугацаанд бүрэн хийж гүйцэтгэн хүлээлгэсэн өгнө. Тендерийн баримт бичигт заагдсан үе шатны ажлын хуваарь болон, гүйцэтгэгчээс ирүүлсэн тодотгосон үе шатны ажлын хуваарьтай уялдан өөрчлөгдж болно. |
| 8 | Ажлын үе шат | Байгалийн сэргэн ургалтад ажил нь дараах ажилбаруудаас бүрдэнэ. <ul style="list-style-type: none">- Бэлтгэл ажил- Байгалийн сэргэн ургалтад туслах ажил хийх- Талбайг хүлээлгэн өгөх- Зөрчил гологдол арилгах- Тайлан боловсруулах- Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх |
| 10 | Гүйцэтгэх ажлын агуулга, | Бэлтгэл ажил <ul style="list-style-type: none">• Байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг гүйцэтгэх улирлын болон тур ажилчдыг дадлагажуулах; |

| | | |
|----|------------------------------------|--|
| 10 | Гүйцэтгэх ажлын агуулга, үе шатууд | <ul style="list-style-type: none"> • Байгалийн сэргэн ургалтад туслах ажилд хэрэглэгдэх техник тоног төхөөрөмжүүдийн техник үйлчилгээг бүрэн хийн ажилд гараадад бэлэн болгох; • Байгалийн сэргэн ургалтад туслах ажлын технологийн карт, дараалал боловсруулан ажилчдад танилцуулах, мөрдөх /технологийн дарааллын загварыг хавсаргав/ • Байгалийн сэргэн ургалтад туслах ажил гүйцэтгэх талбайг сонгох тэмдэгжүүлэх /Талбай сонгох ажлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын холбогдох мэргэжилтнүүд, аймаг, дүүргийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ойн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, сумын болон сум дундын ойн ангийн инженер техникийн ажилчидтай зөвшшилцөн сонгох/; • Байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа бэлтгэн өгөх; • Байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдад ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга өгөх; • Ойр орчмын иргэдэд мал бэлчээхийг хориглох талаар танилцуулга хийх, уулзалт зохион байгуулах. |
| 11 | | <p>Байгалийн сэргэн ургалтад туслах ажил хийх</p> <ul style="list-style-type: none"> • “Мод сөөг тарьц. Техникийн шаардлага” MNS 6140:2010 стандартад нийцсэн I зэргийн тарьцыг байгалийн сэргэн ургалтад туслах ажилд хэрэглэх • Сонгож тусгаарласан талбайд өвслөг ургамлын өрсөлдөөнийг хязгаарлаж анжсаар шан татах • Нэг га талбайд 800 болон түүнээс дээш тооны тухай орчинд зонхилох төрлийн модны I зэргийн тарьцаар ойжуулах • Байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг гүйцэтгэх ажилчдын 50 хүртэл хувь нь ойролцоо нутгийн малчдаас бүрдүүлсэн байх • Мэдээллийн самбар байрлуулна. Самбарын нийт өндөр 3 метрээс багагүй, төмөр хийцтэй байх бөгөөд самбарын хэмжээ 1x1 метрээс багагүй байна. Самбарын хөлийн бетон зуурмагаар бэхэлсэн байна. Самбарын мэдээлэлд байгалийн сэргэн ургалтад туслах ажил хийсэн талбайн зураг, захиалагч болон гүйцэтгэгчийн тухай мэдээлэл, талбайн хэмжээ, тарьсан модны төрөл, тоо ширхэг зэрэг мэдээллүүдийг заавал оруулсан байна. |
| 12 | | Талбайг хүлээлгэн өгөх |

Байгалийн сэргэн ургалтад туслах ажлын гүйцэтгэлд явцын болон гүйцэтгэлийн, чанарын хяналтыг доор дурдсан байгууллагуудаас хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газраас томилогдсон ажлын хэсэг, төслийн менежер
- Хөндлөнгийн хяналт, мониторингийн баг

Байгалийн сэргэн ургалтад туслах ажил гүйцэтгэсэн талбайг орон нутгаас томилогдсон ажлын хэсэгт актаар хүлээлгэн өгөх ажлыг гүйцэтгэгч зохион байгуулна. Актыг 5 хувь үйлдэх бөгөөд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газарт эх хувиар нь ирүүлнэ. Ажлын гүйцэтгэлийг аймаг, нийслэлийн Засаг даргын томилсон ажлын хэсгийн гаргасан актыг үндэслэн хүлээн авна. Дараах нөхцөлийг хангасан үед уг ажлын гүйцэтгэлийг хангалттай гэж үзэж хүлээн авна. Үүнд:

- Сонгож тусгаарласан талбайд өвслөг ургамлын өрсөлдөөнийг арилгаж анжсаар шан татан 1 га талбайд 800 болон түүнээс дээш тооны тарьц тарьсан нь намрын тооллогоор 75-аас дээш хувийн ургалттай бол;

Тарьсан тарьцын амьдралтын хувийг тогтоохдоо Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 03дугаар сарын 29 өдрийн А-96/71 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу жишиг талбай байгуулан тооллого явуулна.

| Ойжуулсан талбай /га/ | Жишиг талбайн нийлбэрийн ойжуулсан талбайд эзлэх хувь | Нэгж жишигт албайн хэмжээ /м ² / |
|-----------------------|---|---|
| 1-5 | 5 | 200 |
| 6-10 | 4 | 400 |
| 11-20 | 3 | 400 |
| 21-ээс дээш | 2 | 400 |

- Байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хүлээн аваходаа гэрээний ерөнхий ба тусгай нөхцөлийн дагуу зөрчил, гологдолыг арилгасны дараа “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмаар батлагдсан актын дагуу хүлээн авна /Маягтыг хавсаргав/. Ажлыг гүйцэтгэх хугацаанд тухайн аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Сум дундын ойн анги болон сум орон нутагтай хамтран ажиллана.

| | | |
|----|--|---|
| | | |
| 13 | | <p>Зөрчил, гологдол арилгах</p> <ul style="list-style-type: none"> • Тарьсан тарьц нь 50-74,9 хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгч өөрийн зардлаар 90 хувь хүртэл нөхөн тарилт хийж, актаар хүлээлгэн өгнө. • Тарьсан тарьц нь 25-49,9 хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгчид урьдчилгаагаар олгосон норматив зардалд хүрэхүйц шаардлагатай нөхөн тарилтыг гүйцэтгэгчийн хөрөнгөөр хийлгэж дараа жилийн намар хүлээж авна. • Тарьсан тарьц нь 24,9 хувийн амьдралтай тоологдсон тохиолдолд уг ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн гэж үзэж гүйцэтгэгчээр ойжуулалтын ажлын урьдчилгааг эргүүлэн төлүүлнэ. |
| 14 | | <p>Тайлан боловсруулах</p> <p>Байгалийн сэргэн ургалтад туслах ажил гүйцэтгэсэн тайланг захиалагчид З хувь ирүүлнэ. Тайлан дор дурдсан бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:</p> <p>а/ “Байгалийн сэргэн ургалтад туслах ажил гүйцэтгэсэн тайлан”;</p> <p>б/ 1:50000-ны масштабтай байгалийн сэргэн ургалтад туслах ажил явуулсан талбайн зураг;</p> <p>в/ “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын ажлын хэсэг байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт.</p> <p>а. “Байгалийн сэргэн ургалтад туслах ажил гүйцэтгэсэн тайлан”-д:</p> <p>Байгалийн сэргэн ургалтад туслах ажлын үе шат тус бүрээр хийсэн ажлын гүйцэтгэл, ажлын технологийн дараалал, тарилтын схем, тарьц, суулгацын стандартын шаардлага хангасан байдал, ажил гүйцэтгэсэн хугацаа, ажиллах хүчин, ажлын өдөр тутмын гүйцэтгэл, тавьсан хяналт зэрэг мэдээллийг багтаана. Дээж талбайн тооллого болон бусад судалгааны ажлын үед авсан гэрэл зураг, ойн төлөв байдлын зураг, талбайн ерөнхий байдлын зураг, эхлэл төгсгөлийн зургийг харьцуулсан байдлаар фото хэлбэрээр тайланд хавсаргана.</p> <p>б. “Байгалийн сэргэн ургалтад туслах ажил явуулсан талбайн зураг”-т: Хэсэглэл, ялгарлын хил, дугаар, талбай, газрын төрлийн ангилал тэмдэглэгээ, модны төрөл, насны бүлэг, газар ус, уул, өндөрлөг тоотын нэр, газар зүйн</p> |

| | | |
|----|--------------------------|---|
| | | <p>байрлалын солбицлын торлол, зургийн масштаб, проекц, таних тэмдэг эдгээрийг ой зохион байгуулалтын технологийн зааварт заасан стандартын дагуу гүйцэтгэж оруулна.</p> <p>в. “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойт үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын ажил хүлээн авах ажлын хэсэг байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт тайланд хавсаргана. Тайланг захиалагчийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээлгэн өгнө. Хэрэв тайланд зөрчил гологдол илэрсэн бол түүнийг арилгах үүргийг гүйцэтгэгч хүлээнэ. Зөрчил гологдлыг арилгасан тухай төслийн менежер мэдэгдэл гарган дахин даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсны дараа эцсийн шатны санхүүжилтийг олгоно. Зураг боловсруулалтын ажлыг Засгийн газрын 2009 оны 1-р сарын 28-ны өдрийн 25-р тогтоолын дагуу олон улсын WGS-84 солбицлын систем, өндрийн сүлжээний Балтийн тэнгисийн тогтолцоог, том дунд масштабын байр зүйн зураглалд дэлхийн хөндлөн меркаторын UTM (UNIVERSAL TRANSVERS MERCATOR) тусгагийг хэрэглэнэ. Байгалийн сэргэн ургалтад туслах ажлын тайлан болон зургийн shp.файлуудыг цахим хэлбэрээр /CD, DVD/ 1 хувь ирүүлнэ.</p> |
| 15 | | <p>Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх</p> <p>Ажлын тайланг Ойн газарт гурван хувийг хүргүүлнэ. Тайланг зөвшөөрөх хугацааг ажлын үе шатны хуваарыт тусгана. Тайланг нээлттэйгээр хэлэлцүүлнэ.</p> |
| 16 | Бусад тавигдах шаардлага | <ul style="list-style-type: none"> • Ажлын гүйцэтгэхэд шаардлагатай нийт ажилчдын 50 хүртэл хувийг тухайн сум орон нутгийн иргэд, малчдын бүлэг, нөхөрлөлүүдтэй гэрээ байгуулан хамтран гүйцэтгэнэ. • Ойжуулалтын талбайд гарсан хог хаягдлыг цэвэрлэж, хогийн төвлөрсөн цэг рүү тээвэрлэх ажлыг зохион байгуулна. • Ойжуулалтын ажлыг гүйцэтгэх явцдаа ажлын е шат бүрийг захиалагчид фото зургаар баталгаажуулан ирүүлнэ.Үүний дараа дараагийн үе шатны ажлыг эхэлнэ. |

**БАЙГАЛИЙН СЭРГЭН УРГАЛТАД ТУСЛАХ АЖЛЫН ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД
(MNS, ISO9001:2015, UCS)**

Байгалийн сэргэн ургалтад туслах ажлын гүйцэтгэлд гүйцэтгэгч байгууллага нь дараах стандартуудыг мөрдөж ажиллана.

| № | Стандартын нэр | Стандартын тэмдэглэгээ |
|----|--|------------------------|
| 1 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа | MNS 4969:2000 |
| 2 | Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага | M NS 6139:2010 |
| 3 | Мод сөөгний тарьц. Техникийн шаардлага" | MNS 6140:2010 |
| 4 | Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага | MNS 6141:2010 |
| 5 | Мод үржүүлгийн газрын хөрсийг боловсруулах, Ерөнхий шаардлага | MNS 2418:2011 |
| 6 | Мод үржүүлгийн газар бордоо хэрэглэх | MNS 6252:2011 |
| 7 | Мод сөөгний үрийг тарихад бэлтгэх, Ерөнхий шаардлага | MNS 6253-1:2011 |
| 8 | Мод сөөгний үр тарих Ерөнхий шаардлага | MNS 6253-2:2011 |
| 9 | Мод сөөгний үр тарьсны дараа арчлах. Ерөнхий шаардлага | MNS 6253:2011 |
| 10 | Мод сөөгний суулгацыг бойжуулах, Ерөнхий шаардлага | MNS 6254:2011 |
| 11 | Сөөгний суулгац. Ерөнхий шаардлага | MNS 6255:2011 |
| 12 | Сөөгөнцөрийн суулгац. Ерөнхий шаардлага | MNS 6256:2011 |
| 13 | Улиасны суулгац. Ерөнхий шаардлага | MNS 6257:2011 |
| 14 | Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах. Ерөнхий шаардлага | MNS 6258-1:2011 |
| 15 | Мод сөөгний суулгац арчлах | MNS 6258-2:2011 |
| 16 | Улиасны модожсон мөчрийн тайраадас. Ерөнхий шаардлага | MNS 1796:2011 |
| 17 | Бордоо. Доломитын бордоо Техникийн шаардлага | MNS 6662:2017 |
| 18 | Сөөгний суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах Техникийн шаардлага | MNS 6773:2019 |
| 19 | Том мод, суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах | MNS 6774:2019 |
| 20 | Голт борын төрлийн ургамлыг тарих, арчлах. Техникийн шаардлага | MNS 6863: 2020 |
| 21 | Мод үржүүлгийн газарт гоёл чимэглэлийн мод, сөөгний суулгац ургуулах Техникийн шаардлага | MNS 6864:2020 |
| 22 | Навчит модны суулгац, техникийн шаардлага | MNS 6141:2020 |
| 23 | Азот фосфор калийн холимог бордоо, техникийн шаардлага | MNS 5891:2008 |
| 24 | Фосфорын бордоо | MNS 4305: 1996 |

Ажил гүйцэтгэх байршил /багцын мэдээлэл/

| № | Багцын дугаар | Багцын нэр | Талбайн хэмжээ, га | 1 га талбайд таригдах модны модны тоо | 1 га талбайн зардлын норматив, төгрөгөөр | Нийт таригдах модны тоо | Төсөвт өртөг, төг | Талбайн байршил, координат | Талбайн байршил, ОЗБ-ын материал |
|---|---------------|---|--------------------|---------------------------------------|--|-------------------------|-------------------|----------------------------|----------------------------------|
| 1 | Багц 1 | Архангай аймгийн Булган сумын Баянбулаг | 40 | 800 | 740,000.00 | 32,000.00 | 29,600,000.00 | | |
| 2 | Багц 6 | Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Зарманы говь | 20 | 800 | 740,000.00 | 16,000.00 | 14,800,000.00 | | |
| 3 | Багц 7 | Говь-Алтай аймгийн Чандмань сум | 20 | 800 | 740,000.00 | 16,000.00 | 14,800,000.00 | | |
| 4 | Багц 8 | Говь-Алтай аймгийн Бигэр сум | 20 | 800 | 740,000.00 | 16,000.00 | 14,800,000.00 | | |
| 5 | Багц 9 | Дархан-Уул аймгийн Хонгор сумын Хустын булгийн эх | 30 | 800 | 740,000.00 | 24,000.00 | 22,200,000.00 | | |
| 6 | Багц 10 | Завхан аймгийн Яруу сум | 20 | 800 | 740,000.00 | 16,000.00 | 14,800,000.00 | | |
| 7 | Багц 11 | Завхан аймгийн Нэмрөг сумын Баянзүрх баг Хашаат | 40 | 800 | 740,000.00 | 32,000.00 | 29,600,000.00 | | |
| 8 | Багц 12 | Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Урд агуйт | 50 | 800 | 740,000.00 | 40,000.00 | 37,000,000.00 | | |

| | | | | | | | | | |
|------------|---------|--|------------|----------|-------------------|-----------------------|---------------|--|--|
| 9 | Багц 13 | Төв аймгийн Батсүмбэр сумын Үдлэг | 30 | 800 | 740,000.00 | 24,000.00 | 22,200,000.00 | | |
| 10 | Багц 14 | Төв аймгийн Борнуур сумын Сүжигт уул | 30 | 800 | 740,000.00 | 24,000.00 | 22,200,000.00 | | |
| 11 | Багц 15 | Увс аймгийн Цагаанхайрхан сумын Хасын цоорхой | 40 | 800 | 740,000.00 | 32,000.00 | 29,600,000.00 | | |
| 12 | Багц 22 | Хэнтий аймгийн Батширээт сумын Хавтгар | 20 | 800 | 740,000.00 | 16,000.00 | 14,800,000.00 | | |
| 13 | Багц 23 | Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Бугын эрүү, Өвөр асгат | 30 | 800 | 740,000.00 | 24,000.00 | 22,200,000.00 | | |
| ДҮН | | 390 | 800 | - | 312,000.00 | 288,600,000.00 | | | |

Хянасан:

Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга

Б.Ганзориг

Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн Ойжуулалт, ойн нөхөн сэргээлт хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Өсөхбаяр

Боловсруулсан:

Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн Таримал ой, байгалийн сэргэн ургалт хариуцсан мэргэжилтэн

А.Булган